

Харганын дөрвөлжин дэх Хүннүгийн хааны ордны малтлагаар илэрсэн зураасан зургууд

Төмөр-Очирын Идэрхангай^{1,*}, Жаргалсайхны Энхзул²

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Архангай аймгийн Өлзийт сумын нутаг Харганын дөрвөлжин дэх Хүннүгийн хааны ордны тууринд 2020–2022 онд явуулсан археологийн малтлагаар илэрсэн зураасан зургийн талаар өгүүлэх болно. Малтлагын үр дүнд хааны ордны дээврийн их хэмжээний барилгын материалыг илрүүлж, тэдгээрийг лабораторийн түвшинд сэргээн босгох ажлыг гүйцэтгэсэн. Сэргээн засварлах ажлын үр дүнд олон тооны тосгуур, нөмрөг ваарын хагархай хэсгүүд эвлэн нийлж бүтэн болсон ба тэдгээрийн зарим нэг дээр төрөл бүрийн зураасан зураг, тамга тэмдэг илэрсэн нь энэ хотын барилгын материалыг газар дээр нь булж үлдээх бус, нэг бүрчлэн цуглуулж судлах шаардлагатайг харуулж байв.

Түлхүүр үг: Хүннү гүрэн, Лунчэн буюу Луут хот, тосгуур ваар, нөмрөг ваар, бар толгойтой, гөрөөсийн биетэй домгийн амьтан, морь, сэрээ тамга, онгин тамга

Удиртгал

Төв Азийн түүхэнд хамгийн анхны нүүдэлчдийн төрт улс болох Хүннү гүрнийг НТӨ 209 онд Модун шаньюй өнөөгийн Монгол Улсын өндөрлөгт байгуулж, тэд 300 гаруй жилийн хугацаанд оршин тогтнож, өөрсдийн ул мөрийг тодоос тод тамгалан үлдээж чадсан билээ. Хүннү гүрний түүхийг эртний түүхийн эх сурвалж, археологи, угсаатан зүй, хүн судлалын үүднээс судалж, өнөөгийн монголчуудын өвөг дээдэс болох нь нэгэнт тогтоогдож, энэ үзлийг дэлхий нийт хүлээн зөвшөөрдөг болсон юм. Тэд хүчирхэг үедээ Дундад Ази, цаашлаад Зүүн Европ хүртэл цэрэглэн довтолж, өргөн уудам нутгийг эрхшээлдээ оруулан, сүр хүч, нэгдмэл зохион байгуулалтаа дэлхий дахинд харуулж чаджээ. Тэдний энэ агуу түүх, хүч чадал, соёлын өв уламжлал нь эртний түүхийн сурвалжуудад тод томруун тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Тэдний энэ агуу түүхийг өөрсдийнх нь цогцлоон үлдээсэн түүхийн дурсгалууд ч батлан харуулдаг.

Хүннү гүрний түүх нь өнөөг хүртэл дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар ирсэн бөгөөд олон улсын судлаачид тэдний түүх, соёл, гарал үүслийг өөрсдийн онол, үзэл баримтлалд тулгуурлан олон өнцгөөс тайлбарлаж иржээ. Үүний үр дүнд Хүннүгийн тухай судалгааны чиглэл өргөжин тэлж, дэлхийн улс орнуудын эрдэмтдийн бүтээл, судалгааны өгүүллүүд тасралтгүй хэвлэгдэн нийтлэгдсээр байна. Гэвч зарим улс орнууд улс төрийн зорилго, үзэл

суртлын нөлөөгөөр Хүннү гүрний түүхийг өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн тайлбарлах, түүхэн баримт, ойлголтуудыг гуйвуулах оролдлого хийж ирсэн бөгөөд ийм хандлага өнөөг хүртэл байсаар байна. Энэ тал дээр бид ч өөрсдийн түүхийг дутуу дулимаг судалсан, нарийн системтэй судалгаануудыг хийж чадаагүй, түүхэн эх баримтуудаа дэс дараатай зөвөөр тайлбарлаж чадаагүй, цаашлаад өөрийн орны эртний түүхийн гарал үүслийг бусдын нутгаас хайдаг зэргээс шалтгаалж байгааг үгүйсгэх аргагүй юм. Мөн дан ганц биднээс хамаарахаас гадна манай улс Шинжлэх ухаандаа сул анхаардаг, түүхийн зарим чухал судалгаануудаа төрөөс дэмжлэг үзүүлдэггүй, цаашлаад зарим онцгой дурсгалуудаа төрийн ивээл доор авч, судалгаа шинжилгээний ажлуудыг шат дараатай, системтэй дэмжин явуулдаггүй зэргийг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Хүннү гүрний үеийн археологийн дурсгалыг судлах ажил 100 гаруй жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд жил ирэх тусам судалгааны хүрээ өргөжин тэлж, судалгааны арга аргачлал ч улам боловсронгуй болов. Үүний үр дүнд түүхийн олон эдрээтэй асуудлууд гадаад, дотоодын хамтын ажиллагаа, дэмжлэгийн хүрээнд тодорхой хэмжээнд шийдэгдэж, цэгцэрч байна. Гэсэн хэдий ч 300 гаруй жилийн турш үргэлжилсэн Хүннү гүрний түүхийн олон зангилаа асуудлууд өнөөг хүртэл бүрэн тайлагдаагүй хариултаа хүлээсээр байна.

Малтлага судалгаа

Бид хүннү булшны бүртгэл судалгааны ажлыг гүйцэтгэх явцдаа 2017 онд Архангай аймгийн Өлзийт сумын Харганын дөрвөлжин хэмээх газраас

¹ МУИС, ШУС, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим,
Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

² Төв аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан

* Холбоо барих зохиогч: iderkhangai.t@num.edu.mn

эртний нэгэн хотын туурийг анх илрүүлэн олж, улмаар 2019 оны зун газар дээр нь очиж шалгахад барилгын материал маш ихээр тархсан байсан бөгөөд тэдгээрийн дотор “шаньюй” гэсэн бичигтэй барилгын дээврийн чимэглэл нүүр ваарын хагархай байсныг анх түүврээр олсон юм. Шаньюй гэдэг бол Хүннүгийн хааныг нэрлэдэг нэр болно. Учир иймд дээрх судалгааг гүнзгийрүүлэх зорилгоор 2020 оны 4 дүгээр сард дахин газар дээр нь очиж агаарын зураглал, нарийвчилсан хэмжилт, тандалт судалгааг явуулахад “Тэнгэрийн хүү Шаньюй” гэсэн бичигтэй нүүр ваарын хагархай түүвр байдлаар 2 илэрч олдсон нь бидний дээрх таамаглалыг улам баталгаажуулав. Гэвч энэ судалгааны ажлууд тухайн дурсгалын газрын өнгөн хөрсөн дээрх түүвр олдворт тулгуурлагдаж байсан учир энэ судалгааг улам батлах зорилгоор 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс 25-ны хооронд Улаанбаатарын Их Сургуулийн захирал доктор (Sc.D), профессор С.Байгалсайханы дэмжлэгээр анхны археологийн малтлага судалгааны ажлыг эхлүүлсэн билээ.

Бид 2020 оны зун хааны ордны дотор хэрмийн баруун урд талын дунд хэсэгт 7×10 м, баруун урд талын урд хэсэгт 2×16 м, гадна хэрмийн хойд хэсгийн дунд орчимд 25×1 м буюу гурван жижиг талбайд нийт 127 м^2 зүсэлтийн малтлагыг гүйцэтгэсэн бол 2021 онд дотор хэрмийн баруун урд буланд 487 м^2 , 2022 оны зун дотор хэрмийн өмнөд хаалгын хэсэгт 650 м^2 талбайг тус тус малтан судалж тус хотын дотор хэрмийн 3 хэсэг газарт археологийн малтлага судалгааг гүйцэтгэсэн болно (Зураг 01). Эхний жилийн малтлагаар дотор хэрмийн баруун урд буланд байгуулсан 90×60 м хэмжээтэй усан санг усаар хангаж байсан чулуун болон вааран хоолойг илрүүлэн усан сангийн усны хангамжийн асуудлыг тогтоосон бол 2 дахь жилийн малтлагаар дотор хэрмийн баруун урд буланд 16 модон багана бүхий 2 давхар, нүсэр том модон байгууламж бүхий вааран дээвэртэй барилга байсныг, 3 дахь жилийн малтлагаар өмнөд хаалга маш том болохыг, түүнийг асар том талбайгаар үргэлжлүүлэн малтахыг мэдэж авахын зэрэгцээгээр тус хотын барилгын хийц загвар, технологийн зарим асуудлыг таньж мэдсэн болно.

Харганын дөрвөлжин дэх Хүннүгийн үеийн хот нь 550×550 м хэмжээ бүхий гадна хэрэмтэй, гадна хэрмийн дотор талд төв хэсэгт 250×210 м хэмжээ бүхий дотор хэрэмтэй, дотор хэрмийн төв хэсэгт 1 жижиг, 2 том ордны суурь, мөн дотор хэрмийн баруун урд хэсгийн гадна талд залгуулж байгуулсан 1 том ордны суурьтай ажээ. Түүнчлэн дотор хэрмийн хойд, зүүн, урд болон баруун талд илэрхий мэдэгдэх хаалгатай бөгөөд хаалга тус бүрээс төв хэсэгт орших 2 том ордон руу холбосон замтай байна. Хамгийн сонирхолтой нь тус хотын дотор хэрмийн баруун урд

хэсэгт $1/4$ -т хүний гараар байгуулсан маш том усан сантай байгаа нь өндөр зэрэглэлийн, тансаг, хааны ордон болохыг илэрхийлж байгаа юм. Мөн гадна хэрмийн гадна талын баруун хэсэгт 2, зүүн хойд хэсэгт 3 ширхэг хотын дагуул бусад барилгын үлдэгдэл байгаа нь хотыг тойроод орд харшууд хийгээд хэдэн арваас хэдэн зуугаар тоологдох гэр өргөөд сүндэрлэж байсныг илтгэнэ (Зураг 2).

Бид энэ хотын он цагийг тогтоох зорилгоор 2023 онд Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын үйлвэрлэлийн түүх” төслийн хүрээнд Харганын дөрвөлжингийн үйлдвэрлэлийн газарт малтан 2-р зуухнаас 6 ширхэг модны нүүрсийг Япон улс руу илгээж, C14 задлан шинжилгээ хийлгэхэд 200-45calBC (95.4%), 180-45calBC (93.8%), 180-40calBC (95.4%), 200-50calBC (92.4%), 205-90calBC (76.2%), 200-50calBC (94.3%) хэмээх он цагууд гарсан юм (Зураг 11). 2-р зуух НТӨ II-I зууны үед хамаарч байгаа нь тогтоогдов.

Энэ он цаг тогтоох шинжилгээний үр дүнгээр Харганын дөрвөлжингийн дурсгалын он цагийг баримжаалахад ихээхэн чухал зүйл болж байгаа бөгөөд тус хотыг НТӨ II-I зууны үед бүтээн байгуулсан болох нь батлагдаж байна. Тиймээс Хүннү гүрний улс төрийн төв болох Орхон, Тамирын голын сав газарт Хүннү гүрний эхэн үед тухайн хотыг бүтээн байгуулж, төрт улсын үйл хэргийг удирдан зохион байгуулж байсныг харуулж байна. Монгол нутаг орших Хүннү гүрний хотуудаас нэлээдгүй хэдийг малтан судалж он цагийг тогтоосон байдаг бөгөөд Харганын дөрвөлжин дэх тус хотын он цаг НТӨ II-I зууны үед гарсан явдал өнөөдрийн байдлаар Монгол нутаг дахь Хүннүгийн үеийн хотуудаас хамгийн эртний он цагтай хот болж буйгаараа түүхэн чухал ач холбогдолтой юм.

2020-2022 оны малтлагаар илэрсэн дээврийн барилгын материалуудаас 2020, 2021 оны олдворуудыг лабораторийн түвшинд боловсруулах ажлыг хийж эхлүүлсэн билээ. Ингэхдээ 2020 онд илэрсэн 5700 орчим ваарын хагархайг бүрэн, 2021 онд илэрсэн 70,000 орчим ваарын хагархайгаас $1/3$ хэсгийг угааж цэвэрлэн эвлүүлэн наах ажлыг бүтэн 2 жилийн туршид явуулахад маш их мэдээллийг бидэнд өгсөн билээ.

Дотор хэрмийн тулгуур баганууд он цагийн уртад өгөршин хугарч унахад вааран дээвэр газарт олон хэсэг болон бутарч унаад 2000 гаруй жилийн хугацаанд булагдаж харагдахаа больсон байна. Бид малтлагаас илэрсэн барилгын олон мянган дээврийн ваарын хагархайг малтлагын талбай дээрээс нэг бүрчлэн бүртгэн баримтжуулж (Япон улсын жишгээр) лабораторийн түвшинд эвлүүлэн нааж сэргээн босговол тухайн хэрмийн бүтэц зохион байгуулалт, барилга архитектурийн асуудлыг бүрэн тодорхойлох боломжтойг мэдэж авсан юм. Энэ нүсэр ажлыг

явуулахад хүн хүч, цалин хөлс, цаг хугацаа, зай талбайнаас эхлээд олон асуудлууд зэрэг хөндөгдөх нь ойлгомжтой байв. Энэ ажил ч бидний хувьд анхны томоохон туршлага болох нь тодорхой болов. Бид шавь нартайгаа ярилцсаны эцэст тодорхой ажлуудыг эхлүүлж, үр дүнд хүрч чадсан билээ.

Барилгын материалуудыг эвлүүлэн наах явцад бичигтэй нүүр ваарнуудын хэв дардас тодорхой болохоос гадна барилгын материал дээрээ нүүдэлчдийн ахуйг харуулсан зураасан зургуудыг зурж үлдээсэн явдал лабораторийн ажлын явцад ихээхэн анхаарал татаж байв. Тодруулбал, 2020 оны малтлагын олдворуудыг сэргээн эвлүүлэх явцад сэрээ тамга болон ширээтэй сэрээ тамгын дүрслэлүүд тосгуур, нөмрөг ваарын хэд хэдэн өөр хэсэгт зурагдсан байв. Харин 2021 онд дотор хэрмийн булангийн малтлагаас илэрсэн барилгын материалын 1/3 хувийг Улаанбаатарын Их сургуулийн захирал С.Байгалсайханы дэмжлэгтэйгээр, тус сургуулийн 4 дүгээр давхрын хурлын зааланд 2021 оны 11 дүгээр сарын 1-нээс 2022 оны 5 дугаар сар хүртэл угааж цэвэрлэх, эвлүүлэн наах ажлыг зохион байгуулав (Зураг 3). Уг ажлын үр дүнд олон олдвор бүтэн болсон бол (Зураг 4), 3–4 ширхэг сэрээтэй онгин тамга шинээр эвлэв. Мөн барын толгойтой, гөрөөсийн биетэй домгийн амьтны дүрслэл шинээр илэрсэн нь сонирхолтой чухал олдвор боллоо (Зураг 5–7).

Малтлагаас гарсан сэрээ, онгин тамгууд хожмын XIII–XIV зууны үеийн Монголын эзэнт гүрний хаадын тамгатай хэлбэр дүрсээрээ ижил байгаа нь түүхийн чухал холбоос бүхий баримт болж байна. Түүнчлэн олон тооны тосгуур, нөмрөг ваарнууд шинээр эвлэрч бүтэн болсноос гадна “Тэнгэрийн хүү шаньюй, тэнгэр мэт хязгааргүй, өнө мөнх насалтугай” гэсэн бичигтэй нүүр ваарнууд маш олноор эвлэж бичиг нь бүрэн тайлагдах болсон (Зураг 8) зэрэг нь тухайн хотын түүхэн үнэ цэн, ач холбогдол хийгээд барилга, архитектурийн нарийн түүхийн ээдрээтэй асуудлыг ч сэргээн тодруулахад асар чухал судалгаа болсныг илтгэхийн дээр барилгын материалуудыг тухайн газар дээр нь орхих, үлдээх нь хэр оновчтой вэ гэсэн асуулт ч үүсч байгаа юм. Мэдээжийн хэрэг бичиг үсэг, зураасан зураг, тамгатай олдворууд зөвхөн энэ хотын онцлог байхыг үгүйсгэхгүй аргагүй.

2022 оны малтлагыг тус хотын өмнөд хаалгын зохион байгуулалтыг тодруулах зорилгоор 650 м² талбайг цэвэрлэн ажилласан боловч тухайн сонгосон талбайд ордны хэрмийн хаалга бүрэн багтаагүй учир малтлагыг өшөө тэлэх болж, бид тухайн малтлагын цэвэрлэгээний үед илэрсэн олон мянган ваарны хагархайг огт хөндөлгүй газар дээр нь үлдээж дараагийн малтлагаар үргэлжлүүлэхээр гялгар уутаар хучиж нөхөн сэргээлтийг хийсэн билээ. Гэвч цэвэрлэгээний явцад хаалгын төв хэсэг, ордон руу явах

хэсгийн орчмоос зураасан зурагтай байж болзошгүй хэрчлээс, зураастай олон ваарны хагархайнууд нэг доор хэд хэдэн газар байсны нэг хэсэг газрын томоохон төвлөрөл хэсгийг баримтжуулан авч лабораторийн түвшинд эвлүүлэн нийлүүлэх ажлыг явуулахад нүүдэлчдийн ахуйтай холбоотой онц сонирхолтой зургууд эвлэж нийлсэн нь энэ хотын түүхийг улам тодруулах, яагаад өмнөд хаалгын ордон руу явах хэсэгт зурагтай байгаа, ер нь бусад хэсгүүдээс яагаад тамга тэмдгийн зүйлс олноор илэрч гараад байгаа зэрэг нь ихээхэн сонирхолтой юм. Үүний цаана ямар онцлог түүх нуугдаж буйг тайлах шаардлага ч тулгарч байна.

Зураасан зураг бүхий олдворууд

Бид энэ хотын дотор хэрмийн 3 хэсэг газарт археологийн малтлагын ажлыг явуулахад малтлага хийсэн талбай бүрээс тамга тэмдэг, зураасан зургууд олноор илэрч олдож байгаа нь олон асуулт тавихад хүргэж байна. Учир нь тэдгээр тамга тэмдэг, зургууд энэ хотын түүхтэй холбоотой эсэх, яагаад хүннүгийн бусад хотын барилгын материал дээр байдаггүй, эсвэл байсныг анзаараагүй юу гэсэн асуултууд ч урган гарч байгаа юм. Мэдээж энэ зүйл нь дараагийн судалгаануудыг гүйцэтгэхэд анхаарах нэг зүйл болж байгааг харуулж байгаа юм. Бид хотын малтлагаар гарсан тамга тэмдгийн талаар тусгай судалгааны өгүүлэл бичиж буй учир энд өгүүлэхээс зайлсхийж зөвхөн 2021 оны малтлагаар гарсан домгийн амьтны дүрслэл, 2022 оны малтлагаар өмнөд хаалгын ордон руу явдаг хэсгээс илэрсэн олон дүрслэлүүдээс зарим нэг эвлэсэн онцлог дүрслэлийг энд өгүүлэв.

Бар толгойтой, гөрөөсийн биетэй домгийн амьтны тухай

Олдворын тодорхойлолт. Дээврийн нөмрөг ваар нь 2021 онд HD 1011-2001 F-1 талбайн сувгийн малтлагаар илэрсэн бөгөөд нийт 25 ширхэг хагархай хэсгийг эвлүүлэн сэргээн засварласны үр дүнд бүтэн болж олдворыг бүрэн тодорхойлох боломж бүрдсэн юм. Сэргээн засварлалт хийсний дараа 51 см урт, 19 см өргөн хэмжээтэй болов. Энэхүү дээврийн нөмрөг ваарын нүүр хэсэгт “Тэнгэрийн хүү шаньюй тэнгэр мэт хязгааргүй өнө мөнх насалтугай” гэсэн агуулгатай бичгийг эртний хятад ханзаар бичсэн нь Хүннүгийн шаньюйд зориулсан үг хэллэг гэдэг нь илэрхий бөгөөд тус нөмрөг ваарын баруун хажуугийн ирмэгт, нүүр ваарын үзүүр хэсэгт харагдахаар бар толгойтой, гөрөөсийн биетэй домгийн амьтныг маш тодорхой зурж дүрсэлсэн байна. Харин нүүр ваарын дээд хэсгийн товгор дээр ширээтэй сэрээ тамгыг зурсан нь энэ олдвор ямар олон мэдээллийг нэг доор

агуулж байгааг харуулж байна.

Энэ сонирхолтой зургийг Хүннүгийн хаан төрийн бэлгэдэлтэй холбоотой эртний уламжлалаар бүтсэн дүрслэл хэмээн үзэж байна. Учир нь 2021 оны намар Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн багийнхан бидэнтэй хамтарч манай судалгааны багийн тухайн жилийн үр дүнгээр богино хэмжээний ярилцлага нэвтрүүлгийг бэлтгэн гаргасан бөгөөд энэ нэвтрүүлгээр тухайн жилийн малтлагын явцад бар толгойтой гөрөөсийн биетэй домгийн амьтны зураасан зураг олдсон тухай нэвтрүүлгийн дундуур ярьсан билээ. Гэтэл тухайн нэвтрүүлгийг Монголын бурханы шашины төв Гандантэгчэнлин хийдийн Эрдэм Соёлын хүрээлэнгийн лам Н.Амгалан үзэж хожим зохиогчтой таарахдаа таны яриад байсан зураг их сонирхолтой юм билээ. Тийм дүрслэл хааны ордныг бэлгэддэг, бурханы ёсонд байна. Та бурхны шашны дуаз буюу жанцангийн тухай судлаад үзээрэй. Тэнд үл зохилдох 3 амьтныг дүрсэлсэн байдаг хэмээн анх зөвлөсөн болно. Зөвөлгөөний дагуу холбогдох материалыг үзэхэд бидний судалгаа болон тус хотын бэлгэдэлтэй холбогдож болохоор мэдээлэл байсан тул цааш үргэлжлүүлэн материал цуглуулсан билээ.

Харганын дөрвөлжингийн 2021 оны малтлагаар илэрсэн бар толгойтой, гөрөөсийн биетэй, салаа туурайтай домгийн амьтны дүрслэл (Зураг 09) яалт ч үгүй ихээхэн содон зүйл болох нь илэрхий болов. Яагаад энэ хоёр эвцэлддэггүй, нийлдэггүй, бар нь гөрөөсөө иддэг хоёр амьтныг нэг амьтны дүрд оруулан зурсан явдал Н.Амгалан ламын хэлсэнчлэн үл зохилдох хоёр амьтны нийлэмж дүрслэл болох нь тодорхой байв. Учир иймд бурханы шашинд байх Дуаз буюу Жанцангийн талаар судлах шаардлага гарав. Дуаз гэдэг нь Бурханы шашинд Өлзийт найман тахил гэдэгт багтдаг, түүний долоо дахь бэлгэдэл аж. Тиймээс Өлзийт найман тахилын тухай хийгээд дуаз буюу жанцангийн талаар товч өгүүлье.

Өлзийт найман тахил

Бурханы шашны бэлгэдлүүдийн дотроос Өлзийт найман тэмдэг хамгийн алдартай нь ажээ. Эртний Энэтхэгт их хааны ор суухад хаантныг хүлээн авах ёстой бэлэг сэлт, хамгийн анхны өргөл барьцын зүйлс өлзийт найман тэмдгээр бүрддэг байжээ. Тиймээс бурханы шашнаас ч өмнө үеэс үүсэлтэй гэж болно. Бурханы шашин дэлгэрснээс хойш эдгээр тэмдэг нь Шагжамуни бурханыг гэгээрэлд хүрэх үед агуу их Вед шашны олон бурхадаас түүнд барьсан өргөл барьцыг төлөөлдөг болжээ.

Бурханы сургаалын үүднээс эх болсон зургаан зүйл хамаг амьтныг энх амгалангаар цэнгүүлэх утгыг агуулж байсан найман тахилыг хожим XIV зууны үед хос ёсны засаглалыг явуулж эхэлсэн Хубилай цэцэн

хаан бээр төр шашин түмэн олноо түвшин амгалан байлгахын эрхэм дээд бэлгэдэл болгон хэрэглэжээ. Тэгэхдээ монголчууд нь найман тахилын дүрсийг монгол гэрийн бүтцийн гол, гол шинжүүдтэй холбон тайлбарлаж байжээ. Үүнд:

Хүрдэн эрдэнэ тоонотой

Эрдэнийн шүхэр дээвэртэй

Алтан загасан уньтай

Ариун хумхын хэлбэртэй (гэрийн ерөнхий хэлбэр)

Цагаан лавай зөрүүлэгтэй (дээврийг зөрүүлэн тавьсан байдал)

Өлзий утсан ханатай

Дуаз эрдэнийн туургатай

Тунамал лянхуан цавагтай (унины хоорондох цавгууд цэцгийн дэлбээ мэт харагдах) хэмээн үүнийгээ айл гэр, төр шашин, улс хотлоороо үүрд ариун сайхнаар цэцэглэн хөгжиж, мандан бадрахыг бэлгэдэл болгон олон зууны турш эрхэмлэн ирсэн байна. Тийм болохоор аливаад өлзий хутаг оршуулна хэмэвээс энэхүү найман тахилыг заавал унших буюу орд сүм, эд зүйлсд түүнийг дүрсэлж шүтээн чимэглэл болгон хэрэглэдэг болой. Ийм учраас найман тахилгүй бурханы шашин, түүний сүм дуган, бурханы тахил эд зүйлс тун ховор ажээ. Энэхүү найман тахилыг Эрдэнийн шүхэр хийгээд алтан загас тэргүүтэн, Их сангийн хумх болон лянхуа цэцэг тэргүүтэн, Эргэлэг баруунаа цагаан лавай хийгээд өлзий утсан тэргүүтэн, эрх хүчний дуаз хийгээд эрдэнийн хүрд тэргүүтэн эдгээр дэс дарааллаар өлзийт найман тахилыг байршуулдаг байна. Эндээс ажиглахад өлзийт найман тахил нь нэн эртний уламжлалтай бөгөөд магадгүй бурхан шашнаас ч өмнө Энэтхэгийн хааны орд өргөө болон хаан ор суухад залдаг том бэлгэдэл байсан бололтой байна. Энэхүү уламжлалт бэлгэдлийг бурханы шашинд уламжлуулан хөгжүүлж ирсэн бөгөөд монголчууд ч өөрсдийн зан үйлдээ уялдуулан бэлгэдлийн үндсэн утгыг алдуулалгүй тахин шүтсээр иржээ.

Их эрдэнийн Дуаз буюу Жанцан

Ялгуусан тэмдэг болох дуазыг алт, мөнгө, зэс, даавуу, зураг гэх мэт олон зүйлээр бүтээдэг уламжлалтай бөгөөд гурван давхар унжлагатайг нь Бисман тэнгэрийн дуаз, 9 давхар унжлагатайг нь есөн өлзий давхарлагат дуаз хэмээнэ. Дугариг ба хавтгай нугалбарт алин болох дуазын дээр Гарьт толгойт арслан, Лавай бөгст матар, Халиу үст загас хэмээсэн үл зохилдуулсан гурван амьтны дүрсийг бүтээдэг ба түүгээр үл зохилдох зүгээс машид ялгуусныг бэлгэдмүй. Дуаз нь 9 өлзий давхарлагат дуаз, Бисман тэнгэрийн дуазаас гадна матар, хэрээ, бар, бич, чоно, үхээрийн хүүрэн дуаз тэргүүтэн олон зүйл бий.

Үл зохилдох бүхнийг бүрэн ялагчийн тодорхой

тэмдэг,

Үнэнийг шинжлэн олсон хурц оюуны ишэнд байгуулсан,

Үргэлжид жаргалын төлөөнөө шамдан зүтгэх сэтгэлийн ганжир төгс,

Үнэлж барашгүй энх амгалангийн дуаз нь долоо дахь өлзийт тэмдэг буюу .

Арслан ба хангарьд хоёр, матар ба лавай хоёр, халиу ба загас хоёр, луу ба бар тэргүүтэн өвөр зуур үл зохилдох өөр өөр язгуурын амьтад эвлэлдэн янаглан хурваас алив юунд ч үл дийлдэх агуу их хүчтэн амьтад төрдөг хэмээдэг. Жигүүртний хаан хүчтэн гарьд бээр араатны хүчтэн цагаан арслан лугаа нөхцөн дундаас нь гарьдын толгой жигүүрт, арслангийн биет тэнгэр газрыг эрхшээсэн агуу хүчтэн төрсөн нь найман хөлт арслан хэмээн алдаршсан болой. Арслангийн дөрвөн саварт мөч, гарьдын хоёр жигүүр, хоёр савар лугаа найман мөчтэй тул ийн нэрийджээ. Мөн далайн хүчтэн матар бээр цагаан лавай лугаа нөхцөн дундаас нь лавай бөгст матар цээжит агуу хүчтэн төрсөн нь Лавайт матар хэмээн алдаршив. Гол мөрний хүчтэн халиу бээр загас лугаа хуран нийлснээс дундаас нь халиу биетэй, загасан толгой хайрс үс бүхий агуу хүчтэн төрсөн нь Үст загас хэмээн алдаршив. Эдгээр хүчтэнүүд үл зохилдохуйг ялагч хэмээн ертөнцийн орноо өнөд дуурссан бөлгөө. Өөрийн зүгээс үл зохилдохуйг ялваас өрөөл бүхнийг зохилдуулагч их хүчийг эрхшээдэг нь ийм бөлгөө. Үл зохилдохуйн зүг бүхнийг мятруулагч агуу хүчтэнүүд энэ мэт төрдөг ажгуу. Эдгээрийгаливаад зурж бүтээвээс үл зохилдохуй шулмын үйлийг ялаад, ашидын тэмцэл хямралыг үл гарган амар жаргалан бүхнийг төгсгөж, ариун оюун лугаа үргэлжид зохилдон өлзий хутагийн хурыг буулган, амьтнаа туслах номын шүтэн барилдлага бүхэн бүрдмүй. Аяа гайхамшиг хэмээн алив амьтан эвийг эрхэмлэн нөхөрлөвөөс юунд үл дийлдэхийн их бэлгэдэл болсон үүгээр хамаг амьтан амаржин, алив хүсэл гориллол, санасан бүхэн нь номчлон бүтэхийн өлзий орших болмуй хэмээсэн. Үүнээс улбаалан алив сүм хийд шүтээнийг бүтээхүйд ялан дийлсэн дуазын дээр болон дотор үл зохилдохуйн хямралыг ялагч эдгээр амьтдын дүрс хөргийг бүтээн залдаг их ёсон гарсан. Иймээс эдгээр амьтдын дүрс хөргийг дуазын дээр буюу дотор эс оршоовоос ялан дийлсэн дуазын бэлгэ чанар үл бүрдэх хэмээн ихэд эрхэмлэн дээдлэн ирсэн болой. Энэ үл зохилдох амьтдаар хааны ордон, сүм хийдийг гадны шулмын хорлолоос хамгаалах, юунд ч үл дийлдэх, амар амгаланг бэлгэдсэн их утга агуулга төгс гайхамшигт зүйл ажээ. Тиймээс бидний судлан буй хааны ордны баруун урд булангийн нүсэр байгууламжийн чимэглэлд бар толгойт, гөрөөсийн биет үл зохилдох амьтны нийлэмж дүрслэлийг дээрх утга агуулгын үүднээс сэтгэж дүрслэн үлдээсэн байна.

Бусад зураасан зургууд

2022 оны малтлагын явцад өмнөд хаалгын дотор талд ордон руу явах замын орчмоос олон тооны янз бүрийн зураасан зургууд ихээр илэрч байсны заримыг лабораторийн түвшинд авчирч эвлүүлэх ажлыг гүйцэтгэхэд үл ойлгогдох дүрсүүд дутуу эвлэрч байсан бол зарим нэг дүрсүүд хагас дутуу эвлэрсэн ч ямар зураг болох нь мэдэгдэж байв. Үүнд: 1. Дэлтэй морины толгой, цээжийн хэсэг, 2. Ямаа (зээр)-ийн толгой, хүзүү, цээжийн хэсэг, нуруу, 3. ишиг? эвсэл тугал гэмээр жижиг амьтны толгой, цээжийн хэсэг зэрэг болно. Гэвч эдгээр хагархай хэсэг бүрэн эвлээгүй тул тодорхой дүрслэл, утга санааг бүрэн ойлгох боломж одоогоор алга байна. Учир нь тус оны малтлагаар цэвэрлэсэн бүх олдворууд тухайн газар дээрээ байгаа учир тэдгээрийг авчирч лабораторийн түвшинд эвлүүлэх, наах ажлыг системтэй гүйцэтгэвээс эвлэж бүрэн болох, магадгүй томоохон утга агуулгатай зураг тэнд байгааг үгүйсгэх аргагүй (Зураг 10).

Дүгнэлт

2020 онд Хүннүгийн улс төрийн төв болох Орхон-Тамирын голын хөндийд Хүннү гүрний нийслэл Лунчэн буюу Луут хотыг илрүүлж, анхны малтлага судалгааг явуулсан бөгөөд эртний сурвалжид тэмдэглэгдсэн хот мөн болохыг олон талын судалгаагаар тогтоогоод байна. Энэхүү хотын үйлдвэрлэлийн газарт Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын үйлдвэрлэлийн түүх” төслийн хүрээнд 2-р зуухны ёроолоос илэрсэн шатсан модны нүүрснээс зургаан дээжийг сонгон, Япон улсын он цаг тогтоох лабораторид C14 задлан шинжилгээ хийлгэхэд тус үйлдвэрлэлийн газар НТӨ II-I зуунд байгуулагдсан нь тогтоогдов. Он цагийн шинжилгээгээр гарсан үр дүнгээс харахад Монгол нутаг дахь Хүннү гүрний үеийн хотуудаас хамгийн эртний хот болох нь тодорхой болж, энэ нь Хүннүгийн 4–5 дахь шаньюй болох Гүнчэн, Ичиси шаньюй нарын үед хамаарах боломжтой болохыг харуулж байна.

Монгол орны төв Хангай нурууны Орхон, Тамирын голын сав газар 8 газарт Хүннү гүрний 11 хот байгаагаас Харганын дөрвөлжин дэх хот хамгийн онцгой бөгөөд вааран дээвэртэй өндөр зэрэглэлийн хааны ордон болох нь түүний эргэн тойронд буй энэ үеийн дурсгалууд хийгээд энэ хотод 3 жил явуулсан малтлага судалгаагаар батлагдаж байна. Тус хотыг барьж байгуулах их бүтээн байгуулалтын ажлыг хүннүчүүд өөрсдөө байгуулсан гэхээс илүүтэй Хань улсын Хүннүд зүтгэж байсан жанжид, тэдний туршлагатай урчуудын заавар зөвлөгөөгөөр барьсан нь ойлгомжтой юм.

Хотын бэлгэдэл зүйн хувьд Дундад Азийн

орнуудын хот байгуулалтын жишиг, тэдний туршлага хийгээд бар толгойтой, гөрөөсийн биетэй, салаа туурайтай домгийн амьтныг дотор хэрмийн баруун урд хэсэгт зориуд зурж үлдээсэн нь эртний уламжлалтай, бурхны шашнаас ч өмнө Энэтхэгийн хааны орд өргөө болон хаан ор суухад залдаг том бэлгэдлийг бодолцож анх байгуулахад зориудаар зурж үлдээсэн гэлтэй. Энэ нь үл зохилдохуйн зүг бүхнийг мятруулагч агуу хүчтэнгүүдийг зурж бүтээвээс, хааны ордон сүм хийдийг гадны муу зүйлээс хамгаалах, юунд ч үл дийлдэх, амар амгаланг бэлгэдэж зурсан гэж үзэж байна. Энэ домгийн дүрслэл нь эртний уламжлалтайг харуулахын дээр тус хотыг Хүннү гүрний цэцэглэлтийн эхэн үед Дундад Ази хийгээд Хань улсын хот байгуулалтын аль аль хэв шинжийг агуулж Хүннүгийн зан заншилд уялдуулан байгуулсан Хүннүгийн хааны ордон болохыг гэрчилж байна.

Мэдээж тус хотын археологийн малтлага судалгааг системтэй үргэлжлүүлэн гүйцэтгэж, малтлагаар илэрсэн барилгын материал нэг бүрийг лабораторийн түвшинд сэргээн босгох ажлыг төлөвлөж гүйцэтгэх аваас өөр олон тооны тамга тэмдгүүд, зурагтай ваарнууд олноор эвлэж нийлэх, шинээр ч олон төрлийн зураг дүрсүүд нэмэгдэн гарах, цаашлаад энэ хотын эртний түүхийг тодорхойлоход чухал хэрэглэгдэхүүн болох нь эргэлзээгүй юм.

Abstract

Line drawings discovered during the excavation of the Xiongnu imperial palace at Kharganyn Durvuljin

Tumur-Ochir Iderkhangai and Jargalsaikhan Enkhzul

This paper will discuss the line drawings discovered during the 2020–2022 archaeological excavations at the remains of the Xiongnu royal palace located at Kharganyn Durvuljin in Ulziit soum, Arkhangai aimag. Before addressing the drawings themselves, I will briefly introduce how the site was discovered and summarize the results of the related research. The ruins of the city were first found in 2017. Between 2020 and 2022, small scale excavations and research were conducted at the western, southwestern side of inner gate and southern gate sections of the site as part of the field training program for archaeology students of the Department of Archaeology at Ulaanbaatar State University. As a result of these excavations, a large quantity of roof construction materials from the royal palace was uncovered, and these materials were subsequently restored at the laboratory level. Through the restoration process, numerous fragments of eaves

tiles and ridge end tiles were successfully reassembled. Some of these tiles bore various line drawings and tamgha symbols, demonstrating that the building materials of this city should not simply be left buried in situ but must be collected and studied individually. Consequently, approximately 70,000 fragments of construction materials recovered from the site were recorded and documented one by one. In the laboratory, all finds from 2020, one third of the finds from 2021, and a smaller number of tiles from 2022 were restored and reconstructed. This extensive work was carried out by archaeology students of Ulaanbaatar University enrolled in 2021 and 2022. As a result, many tiles bearing intriguing tamgha symbols and line drawings were restored, and several of the depicted motifs drew our particular attention. In this presentation, I will discuss the history of the site's discovery, the current state of research related to it, and introduce comparative information and evidence concerning some of the line drawings uncovered during the excavations.

Keywords: Xiongnu empire, Luncheng, eaves tile, ridge-end tile, mythical creature with a tiger's head and gazelle's body, horse, sereе tamgha, ongin tamgha

Ном зүй

Идэрхангай, Т., Оргилбаяр, С., Цэнд, Д., Батчимэг, Б., Амгаланбат, Б., Даваахүү, Э., Эрдэнэпүрэв, П., Баянсан, П. (2021) Хүннүгийн хааны зуны ордон Лунчен буюу Луут хот. Монголын төрийн голомт нутаг. УБ., 2021: 75-83.

Алдармөнх, П., Амартүвшин, Ч., Анхбаяр, Б., Батсүх, Д., Баярхүү, Н., Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Идэрхангай, Т., Одбаатар, Ц., Очир, А., Төрбат, Ц., Цэвээндорж, Д., Энхболд, С., Эрдэнэбаатар, Д., Эрдэнэбат, У., Эрдэнэболд, Л., Эрэгзэн, Г. (2016) Монголын эртний булш оршуулга. Монголын археологийн өвв Боть 3. УБ., 2016: 142, 166.

Очир, А., Уртнасан, Э., Энхболд, С., Эрдэнэболд, Л., Эрэгзэн, Г. (2020) Монголын эртний хот сууринв Монголын археологийн өв цуврал. Боть 10. УБ., 2020: 16.

Пүрэвбат, Г. (2016) Их Монголын бурханы шашны урлах ухааны үндсэн мэдэгдэхүүн. (Дэд дэвтэр). УБ., 2016: 560, 616-617, 620-621.

Пүрэвбат, Г. (2018) Монголын уламжлалт урлах амьтдыг дүрслэн бүтээх суурь мэдэгдэхүүн (Тэргүүн боть). Анхны хэвлэл. УБ., 2018: 115-118.

Сүхбаатар, Г. (2005) Даригангын хүүхдийн тоглоом. // Монголын эртний түүх судлал (боть-IV), түүхийн ухааны доктор Гүнжийн Сүхбаатарын эрдэм шижилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл. УБ., 2005: 33.

Ишцэрэн, Л., Идэрхангай, Т., Галдан, Г., Үсүки, И.,

Сагава, М., Шожи, Т., Кияма, К., Накамүра, Д., Кикүчи, Х., Исахая, Н., Накамүра, О. (2023). Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын үйлдвэрлэлийн түүх” төслийн Архангай аймгийн Өлзийт сумын нутагт ажилласан 2023 оны хээрийн шинжилгээний ангийн тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. УБ., 2023: 19, 23.

Идэрхангай, Т. (2021). Архангай аймгийн Өлзийт сумын нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2021 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т. (2018). Говьсүмбэр аймгийн нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2018 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т. (2018). Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Орхон, Сант сумдын нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2018 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Амгаланбат, Б., Баянсан, Б. (2020). Баянхонгор, Өвөрхангай аймгийн зарим сумдын нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2020 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д. (2020). Дундговь аймгийн зарим сумдын нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2020 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Амгаланбат, Б., Даваахүү, Э., Цэнд, Д., Алтансүх, Б., Баянсан, П., Эрдэнэпүрэв, П. (2014) Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2014 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Бадрах, Б., Галбадрах, Б., Эрдэнэ, Ж., Мөнгөншагай, А., Амарболд, Э. (2010). Архангай аймгийн Батцэнгэл сумын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2010 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Баянсан, Б., Уянга, Х. (2020). Архангай аймгийн Батцэнгэл сумын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2020 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Оргилбаяр, С., Амгаланбат, Б., Батчимэг, Б., Баянсан, Б., Хүслэн, Л., Намсрайжамц, А., Уянга, Х., Мөнхжин, М. (2022). Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутаг дахь “Чулуун соёлын өв” төслийн хүрээнд явуулсан археологийн дурсгалын бүртгэл судалгааны ажлын 2022 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д. (2019). Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Орхонтуул, Орхон, Сант, Хушаат, Булган аймгийн Хялганат сумдын нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2019 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Амгаланбат, Б., Буяннэмэх, Б., Мөнхжин, М. (2020). Сэлэнгэ аймгийн Сант, Хушаат, Булган аймгийн Хутаг-Өндөр, Баян-Агт, Архангай аймгийн Хайрхан, Өлзийт, Батцэнгэл, Цэнхэр, Төв аймгийн Эрдэнэсант сумдын нутагт явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны ажлын 2020 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Эрдэнэ, Ж., Өнөрбаяр, Б., Эрдэнэпүрэв, П. (2016). Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Алаг уул багийн нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2016 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Өнөрбаяр, Б., Эрдэнэпүрэв, П. (2017). Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Алаг уул, тээл багуудын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2017 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.

Эрдэнэбаатар, Д., Идэрхангай, Т., Мижиддорж, Э., Оргилбаяр, С., Галбадрах, Б. (2009). Улаанбаатарын Их Сургуулийн оюутны танилцах болон үйлдвэрлэлийн дадлага ажлын 2009 оны тайлан. УБИС-ийн ГБСХ. УБ.


<https://zanabazarmuseum.medium.com/%D0%B4-%D0%B4%D0%B0%D0%BC%D0%B4%D0%B8%D0%BD%D1%81%D2%AF%D1%80%D1%8D%D0%BD%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-1910-1984-%D1%83%D1%80%D0%B0%D0%BD-%D0%B1%D2%AF%D1%82%D1%8D%D1%8D%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%BE%D0%BD%D1%86%D0%BB%D0%BE%D0%B3-%D1%85%D0%B8%D0%B9%D0%B3%D1%8D%D1%8D%D0%B4-%D1%83%D0%BB%D0%B0%D0%B-C%D0%B6%D0%BB%D0%B0%D0%BB-9951aab6bc86>

Received: Nov. 14, 2025; Revised: Dec. 5, 2025; Accepted: Dec. 16, 2025





Зураг 1. Архангай аймгийн Өлзийт сумын Харганын дөрвөлжин дэх Хүннүгийн хааны ордны дотор хэрэмний баруун урд болон өмнөд хаалганд явуулсан археологийн малтлагын ерөнхий байдал



Зураг 2. Луут хотыг сэргээн зурсан байдал (Зураач Б.Батцоож)



Зураг 3. Угааж цэвэрлэж буй байдал




Зураг 4. Нааж эвлүүлсний дараа бүтэн болсон байдал




Зураг 5-7. Харганын дөрвөлжингөөс илэрч олдсон сэрээ болон онги тамгатай нөмрөг, тосгуур ваарнууд



Зураг 8. Эвлэрсэн нүүр, нөмрөг, тосгуур ваарны ерөнхий хийц загвар хийгээд “Тэнгэрийн хүү шаныюй тэнгэр мэт хязгааргүй өнө мөнх насалтугай” гэсэн бичигтэй нүүр ваарын дүрслэл



Зураг 9. Бар толгойтой, гөрөөсийн биетэй, салаа туурайтай үл зохилдох амьтны зураг



2022 оны малтлага.
HD 1012-2007 А-10-14 талбайгаас илэрсэн дүрслэл
болон зурагтай дээврийн тосгуур ваарны хэсгүүд

0 5 см

Зураг 10. Бар толгойтой, гөрөөсийн биетэй, салаа туурайтай үл зохилдох амьтны зураг